



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,  
Баянхонгор сум, Номгон баг  
Утас, факс 7044 2584  
E-mail: bayankhongor@audit.gov.mn

АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ  
ХӨДӨЛМӨРИЙН ҮНДЭСНИЙ НАМ-д

2020.08.07 № 1/687

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г \_\_\_\_\_ Г

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн  
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Хөдөлмөрийн үндэсний намаас ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817 - 6 : 2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817 - 8 : 2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон “Алсын хараа-2050”, холбогдох бусад байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг шалгуур болгон авч үзсэн.

• 005020677

## Дүгнэлт


Хөдөлмөрийн үндэсний намаас Баянхонгор аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Хөдөлмөрийн үндэсний намын мөрийн хөтөлбөр /...16... хуудас /-ийг хавсаргав.

Хувийг: Баянхонгор аймгийн Сонгуулийн хороонд

Хавсралт...16...хуудас.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

А.ЦЭЭНЯМ

БОЛОВСРУУЛСАН:

АХЛАХ АУДИТОР

Б.ДОЛЖМАА

АУДИТОР

Б.ЦЭРЭНЧИМЭД